

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

ОНХС-ийн 2023 онд хийгдэх ажлын иргэдээс авсан саналыг нэгтгэн багийн засаг дарга нар болон багийн ажлын албанд зөвлөгөө тусламж үзүүлэн саналыг нэгтгэн ЗДТГ-ын ажлын албанд хүргүүлсэн. Мөн аймгаас ОНХС-ын ажлын хэсэг ирж 2022, 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажил болоод 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын явцтай танилцан ажилласан.

Байгууллагын хагас жилийн аж ахуйн тайлан мэдээг цахим санд бүртгэн шивж тулган баталгаажуулалт хийн хагас жилийн тайланг тушаасан. 2023 оны санхүүгийн тайлан болоод ГХУСАЗЗ-ийн тайланг дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Мөн байгууллагын 2023 оны төсвийн төсөөлийг хийх ажил дээр ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Швейцарын хөгжлийн агентлаг “Нутгийн өөрөө удирдах байгууллагын институтын чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд нарийн бичгийн дарга нарыг чадавхжуулах, сургагч багш бэлтгэх 4 хоногийн сургалтад нарийн бичгийн дарга М.Сонинбаяр хамрагдсан.

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

7 дугаар сарын 10-11 ны өдрүүдэд улсын их баяр наадмыг зохион байгуулан ажиллалаа. Нийт 6 насны 124 морь уралдаж, давхардсан тоогоор 39 хүүхэд унаж уралдлаа. Хүүхэд хамгааллын баг уяач болон унаач хүүхдийн бүртгэлийг 7/9 ны өдөр хийж, 10/11 ны өдрүүдэд хяналт тавьж ажиллалаа.

Е- Mongoloia: Цахим системээс Иргэний үнэмлэхийн лавлагаа – 3, авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа - 2, жолооны үнэмлэхийн лавлагаа-1, нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт – 17, иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа – 5, НАХЯ-ны хилийн ба дотоодын цэрэгт цэргийн алба хаасан тухай архивын лавлагаа - 2 , нийт - 26 лавлагаа олголоо.

Сүхбаатар аймгийн сурын холбооноос тэргүүн, гоц харваач ирж Үндэсний сурын спортыг сонирхогчдод сургалт зохион байгуулан ажилласан.

Пэйж хуудсанд энэ сар нийт 18 пост(мэдээ мэдээлэл) оруулсан. Халзан сумын албан ёсны вэб сайт болох Khalzan.su.gov.mn хандах эрхийг олж авч веб сайтны хөгжүүлэлт болон нэмэх зүйл дээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ХНУМС-д төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон цалингийн өөрчлөлт, төрийн захиргааны албан хаагчийн ангилал зэрэглэлийг шинэчлэн орууллаа.

7-р дугаар сард нийт ирсэн бичиг 14, хариутай -5, үүнээс хугацаанд нь илгээсэн -5, хугацаа болоогүй -1, явсан бичиг -10 байна.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:

7 дугаар сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 59.2 сая төгрөг авч орон нутгийн төсвийн байгууллагуудад 80.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хагас жилийн санхүүгийн тайланг сангийн яамны mof.gov.mn сайтад, 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг хийж Fiscal программд шивж нэгтгэн аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлээ.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн пүрэв гаригт цахимаар зохион байгуулагддаг сургалтад нийт 17 албан хаагчдыг хамруулж ажиллалаа.

Засгийн газрын 2023 оны 240 болон 241 дүгээр тогтоолуудаар ЗДТГ ын албан хаагчдад сонсгол мэдээллийн цагаар мэдээлэл өгч ажиллав.

Мөн үер ус их байгаатай холбоотой үер ус, тогтоол усанд бага насны хүүхдийг унаж бэртэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор брошур тараан цахим худсаар мэдээ мэдээлэл өгч ажиллалаа.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Эрүүл мэндийн чиглэлээр: 2023 оны 07 сард Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал Үйлчүүлэгчийг танин тодруулах, Амилуулах тусламж үйлчилгээний сургалтанд эмч мэргэжилтэнгүүд ЭМГ-т сургалтанд хамрагдсан .

Мал эмнэлэгийн чиглэлээр: Аймгийн засаг даргын 2023 оны 04 сарын 21 ны өдрийн А/248 тоот захирамжийн дагуу сумын засаг даргын 2023 оны 04 сарын 25 ны өдрийн А/42 тоот захирамжийн дагуу 4 ажлын хэсэг гарч тарилгыг хийж гүйцэтгэлээ. Сумын хэмжээнд ОХУ-ын 2022 оны 09–р сард үйлдвэрлэсэн 600901 серийн дугаартай 16,400 тун вакцин татан авч тарилгын 4 групп –д хуваарлан вакцинжуулалт 93 хувьтай хийгдсэн. Нийт 13835 үхэрт 27670 мл вакцин зарцуулж хэвийн хорогдлоор 2130 мл ыг устгаад байна. Малын эмч 4, техникч 2 туслах ажилтан 4 нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй тарилгын 5 групп ажиллаа. Сумын засаг даргын гамшгаас хамгаалах зардлаас 4 хувийн хэвшлийн малын эмч нарт 105 л бензин шийдвэрлэж өгсөн.

Байгаль орчны чиглэлээр: Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 02 тоот албан даалгаварын биелэлтийг гаргаж аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлэв

Байгаль хамгаалах зардлаас 64.5 сая төгрөгөөр хог зөөврийн өөрөө буулгагч КАМА маркийн авто машиныг худалдан авлаа.

Байгалийн нөөц ашигласаны тухай хуулийн хэрэгжилт түүнийг захиран зарцуулах тухай зөвлөгөөн Баруун-Урт суманд болж үүнд сумын ИТХ-ын дарга Ө. Золжаргал, Санхүү төрийн сангийн мэргэжилтэн Д. Гэрэлцэцэг нарын хамт оролцлоо

Сумын төвийн айл өрхүүдийн хашааны элсийг зөөж цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэлээ

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:
М.ХУЯГ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Д.ДАЙРИЙМАА